



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**“АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН
ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨЛТ,
ЗАРЦУУЛАЛТ, ГҮЙЦЭТГЭЛ ”**

Аудитын код: ДГА-2020/06-ГА

Цахим хуудас:
www.dornogovi.audit.mn

Дорноговь аймаг
2020 оны 11 сар

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn

Аудитын менежер: Ч.Хэрлэнчимэг

Утас: 70523020 Цахим хаяг: kherlenchimegch@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Лүндэгмаа

Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn

Гэрээт ажилтан: З.Давааням

Б.Ариунбаатар

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	3
Хүснэгтийн товъёог.....	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5-6
БҮЛЭГ 1. СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНООС ИРҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖ, АРГАЧЛАЛЫГ ҮНДЭСЛЭН САНХҮҮЖИЛТИЙГ ХУВААРИЛАХДАА ЗАРИМ ЗАРДЛЫГ ЗӨРҮҮТЭЙ ТООЦООЛЖЭЭ.	
1.1. АСХ-оос зарим зардлыг СЕХ-оос ирүүлсэн аргачлал, зөвлөмжийг баримтлаагүй хуваарилсан байна.....	7-9
1.2. Зарим ССХ нь хэсгийн хороодод төсвийг хуваарилахдаа зөвлөмжийг баримтлаагүй байна.....	9
БҮЛЭГ 2. УЛСЫН ТӨСВӨӨС ХУВААРИЛСАН ХӨРӨНГӨНД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙГЭЭС АРВИЛАН ХЭМНЭЛТГҮЙ ЗАРЦУУЛЖЭЭ.	
2.1. Сонгууль зохион байгуулах 4.0 сая төгрөгийн зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.....	9-12
2.2 Зарим зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнаагүй байна.....	12-13
2.3. Засгийн газрын нөөц хөрөнгө, аймгийн ОБГ-аас нэг удаагийн хамгаалах хэрэгслийг олгосон ч сонгогчдод зориулсан амны хаалтын хүрэлцээ хангалтгүй байсан байна.....	13
2.4. Аймаг сумын СХ-ны хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтын үр нөлөө хангалтгүй байна.....	14
Тайлбар	
ДҮГНЭЛТ:.....	15
Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал:.....	16-20
Холбогдох байгууллагаас ирүүлсэн саналд өгөх тайлбар:.....	21

Товчилсон үгийн тайлбар

АНСДИТХСТ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
АСХ	Аймгийн сонгуулийн хороо
ССХ	Сумын сонгуулийн хороо
СХ	Сонгуулийн хороо
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОБГ	Онцгой байдлын газар
НББ	Нягтлан бодох бүртгэл

Хүснэгтийн товъёог:

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Туршилтын болон санал авах өдөр дүн мэдээ дамжуулах унааны зардлын төсөв	8
Хүснэгт 2	УБХ-ийн төсөв, гүйцэтгэл	8
Хүснэгт 3	Аймаг, сумдын сонгуулийн хороонд хуваарилсан санхүүжилт, гүйцэтгэл, сая төгрөгөөр	10
Хүснэгт 4	Болзошгүй нөхцөл үүссэн үед хэрэглэх зориулалтаар хуваарилсан хөрөнгийн зарцуулалт	11
Хүснэгт 5	Сурталчилгааны зориулалтаар хуваарилсан хөрөнгийн зарцуулалт	11
Хүснэгт 6	УБХ-ийн сонгууль зохион байгуулахтай холбогдон гарсан зардал	12
Хүснэгт 7	ОБЕГ, ОБГ-аас Дорноговь аймагт хуваарилсан нэг удаагийн хамгаалах хэрэгсэл	13
Хүснэгт 8	Нэг удаагийн хамгаалах хэрэгслийн үлдэгдэл	14

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлийн 9.1, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэлээ.
Аудитын зорилт	Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулан аймгийн сонгуулийн хороо болон холбогдох байгууллагуудад танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд: - Аймаг, сумын ИТХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, аргачлалын дагуу хуваарилсан эсэх, - Аймаг, сумын ИТХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аймаг, сумын сонгуулийн хороо, Улсын бүртгэлийн хэлтэс, Онцгой байдлын газрын сонгуулийн зардлын зарцуулалтыг хамрууллаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 3000-3100, Монгол Улсын төрийн аудитын стандарт-Гүйцэтгэлийн аудит MNS 6817-7:2020, Гүйцэтгэлийн болон Санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт боловсруулав. Дараах хууль эрх зүйн актыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд: - Төрийн аудитын тухай хууль - Төсвийн тухай хууль - Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль - АНСДИТХ-ын сонгуулийн тухай хууль - СЕХ-ны 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам - Холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам.

**Хүндрэл,
бэрхшээл**

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Ариунаа удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Ч.Хэрлэнчимэг хэрэгжүүлж, ахлах аудитор Ц.Лүндэгмаа, гэрээт ажилтан З.Давааням, Б.Ариунбаатар нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитыг 2020 оны 10 дугаар сарын 30-аас 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хооронд хэрэгжүүллээ.

БҮЛЭГ 1. СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНООС ИРҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖ, АРГАЧЛАЛЫГ ҮНДЭСЛЭН САНХҮҮЖИЛТИЙГ ХУВААРИЛАХДАА ЗАРИМ ЗАРДЛЫГ ЗӨРҮҮТЭЙ ТООЦООЛЖЭЭ.

1.1. АСХ-оос зарим зардлыг СЕХ-оос ирүүлсэн аргачлал, зөвлөмжийг баримтлаагүй хуваарилсан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 4 дүгээр тогтоолоор батлагдсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай” журмын 2.3-т “Аймгийн сонгуулийн хороо нь Сонгуулийн ерөнхий хорооноос өгсөн зөвлөмж, аргачлалын дагуу сумын сонгуулийн хороонд холбогдох зардлыг хуваарилна” гэж заасан.

СЕХ-оос Дорноговь аймгийн сонгуулийн хороонд 16 нэр төрлийн зардалд нийт 358.5 сая төгрөгийн санхүүжилт хуваарилан олгосон бөгөөд тухай бүр зардлын зүйл ангилал болон хөрөнгийг зарцуулах талаар холбогдох зөвлөмж, аргачлалыг ирүүлсэн байна.

Аймгийн сонгуулийн хороо нь сонгуулийн зардлын төсвийг АСХ-нд 13 нэр төрлийн зардалд 84.7 сая төгрөг, сумын СХ-дод 9 нэр төрлийн зардалд 273.9 сая төгрөгөөр хуваарилсан байна. СЕХ-оос ирүүлсэн зөвлөмж, аргачлалын дагуу сумдын сонгуулийн хороодод төсвийг хуваарилсан хэдий ч зарим зардлыг тооцож, олгохдоо зөвлөмж, аргачлалыг баримтлаагүй байна. Тухайлбал,

- СЕХ-оос ирүүлсэн төсвийн зарцуулалтын тухай тайлбарт “...мотор түрээслэх зориулалтаар нийт хэсгийн 70 хувиар, 1 санал авах байрт 50.0 мянган төгрөг байхаар хуваарилсан ба зайлшгүй шаардлагатай хэсэгт ашиглах” гэсэн зөвлөмж ирүүлсэн. Харин аймгийн сонгуулийн хороо нь бүх хэсгийн хороод тус бүрд 35.0 мянган төгрөгөөр тооцож хуваарилсан байна.
- АСХ нь СЕХ-оос ирүүлсэн аргачлалын дагуу ССХ-д хуваарилбал зохих 36.0 сая төгрөгөөс 316.5 мянган төгрөгийг дутуу тооцож, өөрийн төсөв дээр нэмж хуваарилсан бөгөөд энэ дүнгээр зардал хэмнэгдсэн байна.
- СЕХ-оос туршилтын болон санал авах өдөр дүн мэдээ дамжуулах унааны зардлыг анх 48 хэсгээр тооцож /нэг хэсэгт 55.0 мянган төгрөгөөр/, 2640.0 мянган төгрөг, нэмэлт санал хураах 2 хэсэгт тус бүр 55.0 мянган төгрөг, нийт 50 хэсэгт 2750.0 мянган төгрөг ирүүлсний дотор Замын-Үүд сумын төвийн 8 хэсгийн хорооны 440.0 мянган төгрөг хуваарилагдаж ирсэн байна. АСХ үүнийг бусад хэсгийн хороодод хуваарилж нэг хэсэгт 66.0 мянган төгрөгөөр тооцож олгосон байна. /Хүснэгт №1/.

**Туршилтын болон санал авах өдөр дүн мэдээ
дамжуулах унааны зардлын төсөв**
Мянган төгрөг

Хүснэгт №1

№	Сумдын нэрс	Нийт хэсгийн хороо	СЕХ-оос өгсөн аргачлал	АСХ-оос хуваарилсан төсөв	Илүү +/- Дутуу/- хуваарилсан төсөв
1	Айраг сум	3	165.0	198.0	33.0
2	Алтанширээ сум	3	165.0	198.0	33.0
3	Даланжаргалан сум	4	220.0	264.0	44.0
4	Дэлгэрэх сум	3	165.0	198.0	33.0
5	Замын-Үүд сум	8	440.0	-	-440
6	Иххэт сум	2	110.0	132.0	22.0
7	Мандах сум	4	220.0	264.0	44.0
8	Өргөн сум	3	165.0	198.0	33.0
9	Сайншанд сум	-	-	-	-
10	Сайхандулаан сум	3	165.0	198.0	33.0
11	Улаанбадрах сум	3	165.0	198.0	33.0
12	Хатанбулаг сум	5	275.0	330.0	55.0
13	Хөвсгөл сум	3	165.0	198.0	33.0
14	Эрдэнэ сум	4	220.0	264.0	44.0
15	Нэмэлт санал хураалт	2	110.0	110.0	-
Нийт дүн		50	2,750.0	2,750.0	440.0

АСХ дээрх зардлуудыг хуваарилахдаа дээд шатны байгууллага болох СЕХ-оос ирүүлсэн зөвлөмж, аргачлалыг зөрчсөн байна.

УБЕГ-ын 2020 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/1304 дүгээр тушаалаар Дорноговь аймагт 50,985.9 мянган төгрөгийн төсөв батлагдаж, санхүүжилт хийгдсэн байна.

УБХ-ийн төсөв, гүйцэтгэл

Хүснэгт №2

	Зардлын төрөл	Төсөв	Гүйцэтгэл
1	Мөнгөн урамшуулал	34,038.8	33,794.4
2	Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх, хүргэхэд шаардагдах зардал	3,986.2	3,283.0
3	Сургалт зохион байгуулах зардал	7,462.0	8,449.3
4	Техник хэрэгсэл тээвэрлэх болон шуурхай багийн зардал	5,499.0	5,458.2
Дүн		50,985.9	50,984.9

1.2. Зарим ССХ нь хэсгийн хороодод төсвийг хуваарилахдаа зөвлөмжийг баримтлаагүй байна.

АСХ-оос зардлыг зүйл, анги хооронд нь шилжүүлэхгүй байх, оновчтой зөв хуваарилж, хяналттай, хэмнэлттэй зарцуулах талаар ССХ-дод зөвлөмж өгсөн байна. СЕХ-оос хүн амын төвлөрөл, газар нутгийн хэмжээ зэргийг үндэслэж шуудан холбооны болон унааны зардлыг хуваарилах зөвлөмж ирүүлснийг баримтлаагүй байна. Тухайлбал:

Айраг ССХ төвийн хэсгийн шуудан холбооны зардлыг өсгөсөн, бусад сумд унааны зардлын төсвийн хуваарилалтад өөрчлөлт оруулжээ. Сайхандулаан ССХ эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардал, дүн мэдээ дамжуулах унааны зардлыг шатахууны зардалтай нэгтгэн СХХ-дод ахин хуваарилан зарцуулсан бөгөөд санал авах байрны цахилгаан эрчим хүчний зардалд 992.0 мянган төгрөг, дүн мэдээ дамжуулах, хүргэх зардлыг 480.0 мянган төгрөгөөр тус тус тооцсон байна.

БҮЛЭГ 2. УЛСЫН ТӨСВӨӨС ХУВААРИЛСАН ХӨРӨНГӨНД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙГЭЭС АРВИЛАН ХЭМНЭЛТГҮЙ ЗАРЦУУЛЖЭЭ.

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан уу?

2.1. Сонгууль зохион байгуулах 4.0 сая төгрөгийн зардлыг зориулалт бусаар болон үр ашиггүй зарцуулсан байна.

Сонгуулийн хороо:

АНСДИТХСТ хуулийн 10 дугаар зүйлд Орон нутгийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбоотой зардлыг СЕХ-ны төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ гэж заасан байна.

Дорноговь аймагт 2020 онд аймаг, сумын ИТХ-ын сонгуулийг зохион байгуулахтай холбоотойгоор аймгийн сонгуулийн хороонд хуваарилагдаж ирсэн 358.5 сая төгрөгөөс 16 төрлийн зардалд 350.4 сая төгрөг зарцуулж, 8.1 сая төгрөгийг СЕХ-д буцаан төвлөрүүлсэн байна.

Аймаг, сумдын сонгуулийн хороонд хуваарилсан санхүүжилт, гүйцэтгэл */сая төгрөгөөр/*

Хүснэгт №3

№	Аймаг, сум	Хуваарилсан	Гүйцэтгэл	Төвлөрүүлэлт
1	Дорноговь аймгийн СХ	84.7	78.9	5.8
2	Айраг сум	16.9	16.4	0.5
3	Алтанширээ сум	13.0	13.0	-
4	Даланжаргалан сум	20.9	20.7	0.2
5	Дэлгэрэх сум	15.8	15.8	-
6	Замын-Үүд сум	25.5	25.0	0.5
7	Иххэт сум	13.3	13.2	0.1

8	Мандах сум	19.7	19.5	0.2
9	Өргөн сум	16.8	16.8	-
10	Сайншанд сум	38.3	38.3	-
11	Сайхандулаан сум	17.0	17.0	-
12	Улаанбадрах сум	16.4	16.2	0.2
13	Хатанбулаг сум	24.0	23.4	0.6
14	Хөвсгөл сум	16.2	16.2	-
15	Эрдэнэ сум	20.0	20.0	-
Нийт		358.5	350.4	8.1

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасан байна. Мөн СЕХ-ны 2016 оны 4 дүгээр тогтоолын 3.2-т “Сонгуулийн хороод нь хуваарилсан зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэхгүй бөгөөд шаардлагатай бол дээд шатны сонгуулийн байгууллагад албан ёсоор хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ” гэж заажээ.

СЕХ-оос дээрх журамд заасны дагуу аймгийн сонгуулийн хороонд төсвийг зүйл анги хооронд нь шилжүүлэхгүй байх, зардлыг өөр зориулалтаар хэрэглэхгүй байх гэсэн чиглэл өгсөн хэдий ч ССХ нь дээд байгууллагын зөвшөөрөлгүйгээр зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна. Тухайлбал,

- Аймаг, сумын сонгуулийн хороодод зайлшгүй хэрэгцээ шаардлагатай хэсэгт ашиглуулах зориулалтаар эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх 2.4 сая төгрөг баталсан байна. Уг зардлыг санал авах байрыг гэрэлтүүлэх, эрчим хүчний эх үүсвэр дутагдалтай болон цахилгаан тасарсан үед ашиглах, мотор түрээслэх зориулалтаар зарцуулахыг СЕХ-оос анхааруулсан байхад 9 сумын сонгуулийн хороод уг зардлын санхүүжилтээс шатахуун худалдан авч 1.6 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.
- Байгалийн гэнэтийн аюул, цаг агаарын нөхцөл байдал хүндрэх, зам хаагдах, холбоо тасрах тохиолдолд онцгой байдлын зориулалтаар болзошгүй зардалд 6.6 сая төгрөг олгосон байна. Гэвч 3 ССХ аймгийн сонгуулийн хорооны зөвшөөрөлгүйгээр 0.6 сая төгрөгийг зарцуулжээ.

Болзошгүй нөхцөл үүссэн үед хэрэглэх зориулалтаар хуваарилсан хөрөнгийн зарцуулалт

- Хүснэгт №4

№	Сумдын сонгуулийн хороо	Дүн /мян.төг/	Зарцуулсан зардлын ангилал
1	Дэлгэрэх	160.4	Шатахуун худалдан авсан
2	Иххэт	171.3	Эрчим хүчний эх үүсвэр түрээсэлсэн
3	Мандах	285.5	Шатахуун худалдан авсан
НИЙТ ДҮН		617.2	

- Саналаа хэрхэн өгөх, саналын хуудас хэрхэн тэмдэглэх, санал авах байрны байршил, бусад мэдээ мэдээллийн тухай сурталчилгааг гудамжны сурталчилгааны самбар, орон нутгийн телевиз, радио, сонин ашиглан сурталчилгаа хийхэд зарцуулах зориулалтаар 4.9 сая төгрөг олгосон байна. Зарим сумын сонгуулийн хороо өөрсдийн боломжийг ашиглан өнгөт принтерийн хор, фото цаас ашиглан тараах материал хэвлэж, сонгогчдод тараасан байна. Харин доорх 5 сумын СХ холбогдох байгууллагын зөвшөөрөлгүй нийт 1.5 сая төгрөгийг зарцуулжээ.

Сурталчилгааны зориулалтаар хуваарилсан хөрөнгийн зарцуулалт
Хүснэгт №5

№	Сумдын сонгуулийн хороо	Дүн /мян.төг/	Зарцуулсан зардлын ангилал
1	Мандах	140.0	Шатахуун худалдан авсан
2	Сайхандулаан	136.5	Шатахуун худалдан авсан
		213.5	Сургалтын зардалд зарцуулсан
3	Улаанбадрах	350.0	Шатахуун худалдан авсан
4	Хатанбулаг	350.0	Шатахуун худалдан авсан
5	Хөвсгөл	300.0	Шатахуун худалдан авсан
НИЙТ ДҮН		1,490.0	

Мөн СЕХ-оос ирүүлсэн тайлбарт төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах талаар чиглэлийг ирүүлсэн боловч аймаг, сумын СХ бодит байдалд нийцүүлж хэмнэлттэй зарцуулах бодлого баримтлаагүй байна. Тухайлбал,

- Дэлгэрэх, Мандах, Сайхандулаан, Хатанбулаг ССХ нь санал авах байрыг халаах зорилгоор мотор ажиллуулан эрчим хүчний эх үүсгүүрийн зардлыг нэмэгдүүлсэн.
- Хөвсгөл СХХ-ноос Сайншанд суманд оршин суугаа харьяалал бүхий иргэдээс зөөврийн хайрцгаар санал авах үедээ нэг хэсэгтээ хариуцуулаагүй, хэсэг тус бүрийн ажилтан аймгийн төвд томилолтоор ажилласан байна.
- Дэлгэрэх, Өргөн, Сайншанд ССХ санал авах байр тохижуулах зардлаас хөрөнгө бэлтгэсэн.
- АСХ туршилтын болон санал авах өдөр дүн мэдээ дамжуулах унааны зардлын /Замын-Үүд сумын 8 хэсгийн хорооны/ 440.0 мянган төгрөгийг буцааж төвлөрүүлэхгүйгээр бусад хэсгийн хороодод хуваарилж арвилан хэмнэлтгүй зарцуулсан.
- АСХ сургалтын зардлын төсвөөс 456.8 мянган төгрөгийн хүнс ахуйн хэрэглээний зүйлсийг Шанд наран говь ХХК-аас худалдан авсан бөгөөд үүнд ОО цаас, сальфетка, огурцы, боорцог, пичень, чихэр, бохь, талх, хиама, сыр, элэгний нухаш, кофе, сүү зэрэг бүтээгдэхүүн байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хууль болон холбогдох дээд байгууллагын чиглэл, зөвлөмжийг зөрчиж байна.

Улсын бүртгэлийн хэлтэс

Дорноговь аймагт сонгууль зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс аймгийн УБХ-т 50,985.9 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг зориулалтын дагуу зарцуулж 1.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

/Хүснэгт №6/

Улсын бүртгэлийн хэлтсийн сонгууль зохион байгуулахтай холбогдон гарсан зардал

Хүснэгт №6

	Зардлын нэрс	Нийт дүн, сая төгрөг
1	Тээвэр шатахуун	1.8
2	Томилолтын зардал	7.2
3	Сонгуулийн тоног төхөөрөмж тээвэрлэх зардал	3.6
4	Итгэмжлэгдсэн ажилтны хоол, урамшууллын зардал	31.7
5	Шуудан холбооны зардал	0.6
6	Бичиг хэргийн зардал	2.7
7	Албан хаагчдад олгох мөнгөн урамшуулал	3.4
	Нийт дүн	51.0

2.2. Зарим зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, СЕХ-ны 2016 оны 4 дүгээр тогтоолын 4.1-т “Сонгуулийн зардлын дансны орлого, зарлагын гүйлгээнд холбогдох анхан шатны баримтуудыг зохих ёсоор бүрдүүлэн хадгалж, бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу хөтөлнө” гэж заасан байна.

Сумын сонгуулийн хороод 2.1 сая төгрөгийн 2 төрлийн зардлыг тус тус эдийн засгийн ангилал хооронд дээд шатны байгууллагын зөвшөөрөлгүйгээр шилжүүлэн зарцуулсан байна. Тодруулбал болзошгүй нөхцөл байдал үүссэн үед хэрэглэх зориулалтаар олгосон хөрөнгөөс Дэлгэрэх, Иххэт, Мандах сумын СХ шатахуун авсан бол сурталчилгааны зориулалтаар олгосон хөрөнгөөс Мандах, Сайхандулаан, Улаанбадрах, Хатанбулаг, Хөвсгөл сумын СХ шатахуун авсан байна.

2.3. Засгийн газрын нөөц хөрөнгө, аймгийн ОБГ-аас нэг удаагийн хамгаалах хэрэгслийг олгосон ч сонгогчдод зориулсан амны хаалтын хүрэлцээ хангалтгүй байсан байна.

ОБЕГ-ын харьяа 185 дугаар салбараас 2020 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Засгийн газрын нөөц сангаас коронавируст цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд зохион байгуулахад зориулж нэг удаагийн резинэн бээлий 1,986 ширхэг, нэг удаагийн хүнсний бээлий 36,395 ширхэг, спиртэн суурьтай гар ариутгагч 364 литрийг олгосон байна. Мөн аймгийн ОБГ-аас нэг удаагийн амны хаалт 3,000 ширхэг, Замын-Үүд сумын онцгой комиссоос нэг удаагийн амны хаалт 2,750 ширхэг, нэг удаагийн хүнсний бээлий 1,205 ширхгийг тус тус олгосон байна. /Хүснэгт №7/

ОБЕГ, аймгийн ОБГ-аас Дорноговь аймагт хуваарилж, олгосон нэг удаагийн хамгаалах хэрэгсэл

Хүснэгт №7

№	Олгосон байгууллага	Зориулалт	Нэг удаагийн хамгаалах хэрэгсэл			
			Амны хаалт /ширхэг/	Хүнсний бээлий /ширхэг/	Резинэн бээлий /ширхэг/	Гар ариутгагч /литр/
1	ОБЕГ /185	Сонгогч	-	36,395	-	364
2	дугаар салбар/	Сонгуулийн ажилтанд	-	-	1,986	70
3	Аймгийн ОБГ	Сонгогч	3,000	-	-	-
4	Замын-Үүд сумын Онцгой комисс	Сонгогч	2,750	1,205	-	-
Нийт дүн			5,750	37,600	1,986	434
Нийт шаардлагатай тоо			45,795	45,795		458
Сонгогчид дутагдсан хамгаалах хэрэгсэл			40,045	8,195	-	24

Сонгогчдод амны хаалт 40045 ширхэг, бээлий 8195 ширхэг, гар ариутгагч 24 литр дутагдсан байна.

Аймгийн сонгуулийн хороо хамгаалах хэрэгслийг сонгуулийн 70 хэсгийн хороонд хүлээлгэн өгсөн ба хэсгийн хороо хүлээн авсан хамгаалах хэрэгслийг үлдэгдэлгүйгээр зарцуулсан байна. /Хүснэгт №8/

Нэг удаагийн хамгаалах хэрэгслийн үлдэгдэл

Хүснэгт №8

№	Хамгаалах хэрэгслийн нэр	Нэг удаагийн хамгаалах хэрэгслийн хөдөлгөөн		
		Хүлээн авсан	Зарцуулсан	Үлдэгдэл
1	Амны хаалт /ширхэг/	5,750	5,750	-
2	Хүнсний бээлий /ширхэг/	37,600	37,600	-
3	Резинэн бээлий /ширхэг/	1,986	1,986	-
4	Гар ариутгагч /литр/	434	434	-

2.4. Аймаг сумын СХ-ны хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтын үр нөлөө хангалтгүй байна.

СХ-ны 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 3.4-т “... аймгийн сонгуулийн хороо нь сумын сонгуулийн хорооны зардлын зарцуулалтад хяналт тавина” гэж заасан байна.

Аймгийн сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хороодын нягтлан бодогчдод хөрөнгө зарцуулах шийдвэрийг тухай бүр гаргах, эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулахгүй байх, холбогдох тайлан мэдээ, санхүүгийн анхан шатны баримтыг НББ-ийн тухай хуулийн дагуу бүрдүүлж ажиллах зэрэг заавар зөвлөгөөг тухай бүр өгсөн хэдий ч зардлыг холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрлээ. Тухайлбал, болзошгүй зардал, сурталчилгааны зардлыг унааны зардал, сургалтын зардал, эрчим хүчний эх үүсгүүр бэлтгэх зардал зэрэгт зарцуулсан байна.

Мөн ССХ нь хөрөнгө зарцуулах шийдвэр тухай бүр гаргаагүй, эрчим хүчний эх үүсгүүрийн моторын шатахууныг шаардах хуудас бичиж авсан ч тооцооны хуудас, зарцуулалтын тайлангүй, Сайншанд, Дэлгэрэх, Өргөн сумын СХ санал авах байрны зардлаас 546.4 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь АСХ нь сумдын сонгуулийн хорооны зардлын зарцуулалтад тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

Сургалтын зардалд зарцуулсан хөрөнгөнд АСХ-оос хяналт хангалтгүй хэрэгжүүлсэн байна. Тухайлбал 2 удаагийн сургалтад хамрагдсан хүмүүсийн ирцийн бүртгэл бүрэн бус, дэвтэр бал тараасан жагсаалт үйлдээгүй, бичгийн цаас, принтерийн хорыг хэнд өгсөн нь тодорхойгүй, өөрөөр хэлбэл хүн тус бүр материал хүссэн баримт үйлдээгүй, зарлагын баримтын дүнгээр нэг шаардах хуудас бичсэн байна.

Мөн журмын 4.6-д “...аймгийн сонгуулийн хорооны нягтлан бодогч нь сумын сонгуулийн хорооноос ирүүлсэн санхүүгийн анхан шатны баримтыг шалган, акт үйлдэн хүлээн авна...” гэж заажээ.

Үүний дагуу аймгийн сонгуулийн хорооны нягтлан бодогч нь сумын сонгуулийн хорооны нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг шалгаж, акт үйлдэн хүлээн авсан байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

- 1) СЕХ-оос Дорноговь аймгийн сонгуулийн хороонд нийт 358.5 сая төгрөгийн санхүүжилтийг 4 үе шатаар хуваарилан олгосон ба тухай бүрд зардлын зүйл ангилал болон хөрөнгийг зарцуулах талаар холбогдох зөвлөмж, аргачлалыг ирүүлсэн байна.
- 2) УБЕГ-аас сонгууль зохион байгуулах зардалд 51.0 сая төгрөгийг аймгийн УБХ-т хуваарилсан байна.
- 3) Аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-оос ирүүлсэн зөвлөмж, аргачлалын дагуу сумдын сонгуулийн хороодод төсвийг хуваарилсан хэдий ч зарим зардлыг тооцож, олгохдоо зөвлөмж, аргачлалыг баримтлаагүй байна.
- 4) Сонгууль зохион байгуулах эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардлаас 1.6 сая төгрөгийн шатахуун авч зардлыг зориулалт бусаар, 0.5 сая төгрөгийн хүнс, ахуйн материал авч зардлыг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.
- 5) СЕХ-ны зөвлөмж, аргачлалыг баримтлаагүй хуваарилсан 0.4 сая төгрөг, 4.1 сая төгрөгийн зардлыг АСХ-ны зөвшөөрөлгүйгээр зардал хооронд шилжүүлсэн байна.
- 6) Засгийн газрын нөөц хөрөнгөөс сонгогчдод зориулан олгосон амны хаалтын хүрэлцээ хангалтгүй байсан байна.
- 7) Аймаг, сумын сонгуулийн хорооноос хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.

Аудитаар нийт 6.6 сая төгрөгийн зөрчил илрүүллээ.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ



ДОРНОГОВЬ АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг
Утас: (705) 2-30-36, факс: (976) 70523036
И-мэйл: dga.skh2020@gmail.com

2020.11.12 № 47

танай 2020.11.11-ны № 1-6/774 -т

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Ч.АРИУНАА ТАНАА

Аудитын тайлангийн төсөлд тайлбар өгөх тухай

Танайхаас ирүүлсэн аудитын тайлангийн төсөлд дараах тайлбарыг гаргаж байна.

Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийг Дорноговь аймгийн сонгуулийн хороо нь хуулийн дагуу зохион байгуулан ажиллалаа.

Сонгуулийн Ерөнхий хорооноос Аймгийн сонгуулийн хороонд нийт 358550000 төгрөгийн санхүүжилтийг хуваарилан олгосны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан билээ. Аймгийн Сонгуулийн хороонд 78868642 төгрөгийг, сумын сонгуулийн хороодод 271616035 төгрөгийг нийт 350484677 төгрөгийн зардлыг хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн дагуу захиран зарцуулсан болно. Сумын сонгуулийн хороо болон хэсэг тус бүрт нийт 9-н төрлийн зардлыг СЕХ-оос чиглэл өгсөний дагуу болон өөрийн нөхцөлд тохируулан дараах байдлаар хуваарилан шилжүүлсэн болно.

№	Сумдын нэр	Хэсгийн тоо	Бичиг хэргийн зардал	Шуудан холбооны зардал	Унааны зардал	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	Сурталчилгааны зардал	Болзоогүй зардал	Сонгуулийн автоматжуулсан системийн зардал/Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардал	Туршилтын болон санал авах өдөр дүн мэдээ дамжуулах унааны зардал	Урамшуулал, хоолны мөнгө	Нийт дүн
1	Айраг	4	470,000	550,000	2124000	880000	350000	372400	140000	198000	11770000	16,854,400
2	Алтанширээ	4	470,000	550,000	1600000	880000	350000	372400	140000	198000	8470000	13,030,400
3	Даланжаргалан	5	550,000	650,000	3250000	1100000	350000	465500	175000	264000	14140000	20,944,500
4	Дэлгэрэх	4	470,000	550,000	1705000	880000	350000	372400	140000	198000	11110000	15,775,400
5	Иххэт	3	390,000	450,000	1982600	660000	350000	279300	105000	187000	8910000	13,313,900
6	Мандах	5	550,000	650,000	2411350	1100000	350000	465500	175000	319000	13570000	19,590,850
7	Өргөн	4	470,000	550,000	2730985	880000	350000	372400	140000	198000	11110000	16,801,385
8	Сайхандулаан	4	470,000	550,000	2894700	880000	350000	372400	140000	198000	11110000	16,965,100
9	Улаанбадрах	4	470,000	550,000	2346650	880000	350000	372400	140000	198000	11110000	16,417,050
10	Хатанбулаг	6	630,000	750,000	3413500	1320000	350000	558600	210000	330000	16470000	24,032,100
11	Хөвсгөл	4	470,000	550,000	2191660	880000	350000	372400	140000	198000	11110000	16,262,060
12	Эрдэнэ	5	550,000	650,000	3013000	1100000	350000	465500	175000	264000	13440000	20,007,500
13	Сайншанд	9	870,000	1050,000	3545000	1980000	350000	837900	315000	0	29400000	38,347,900
14	Замын-Үүд	9	870,000	1050,000	2525000	1980000	350000	837900	315000	0	17520000	25,447,900
	Дүн	70	7,700,000	9100000	35733445	15400000	4900000	6517000	2450000	2750000	189240000	273,790,445

441520132

Гүйцэтгэлийг дахин хавсаргаж байгаа бөгөөд үр дүнтэй хуваарилж хяналт тавьсны дагуу зохих үлдэгдэл гарч төсөвт эргүүлэн төвлөрүүлсэн болно.

№	Сумын нэр	Хэсгийн тоо	Бичиг хэргийн зардал	Шуудан холбооны зардал	Унааны зардал	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	Сурталчилгааны зардал	Болзошгүй зардал	Сонгуулийн автомат жуулсан системийн зардал/Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардал	Туршилтын болон санал авах өдөр дүн мэдээ дамжуулах унааны зардал	Урамшуулал	Нийт дүн	Үлдэгдэл
1	Айраг	4	470,000	550000	2124000	880000	350000	144000	140000	0	11770000	16,428,000	426,400
2	Алтанширээ	4	470,000	550000	1600000	880000	350000	372400	140000	198000	8470000	13,030,400	0
3	Даланжаргалан	5	550,000	650000	3249900	1100000	350000	465500	175000		14140000	20,680,400	264,100
4	Дэлгэрэх	4	470,000	550000	1705000	880000	350000	372400	140000	198000	11110000	16,775,400	0
5	Иххэт	3	390,000	450000	1982600	660000	350000	279300	105000		8910000	13,126,900	187,000
6	Мандах	5	550,000	650000	2411350	1100000	350000	465500	175000	264000	13570000	19,535,850	55,000
7	Өргөн	4	470,000	550000	2730985	880000	350000	372400	140000	198000	11110000	16,801,385	0
8	Сайхандулаан	4	470,000	550000	2894700	880000	350000	372400	140000	198000	11110000	16,965,100	0
9	Улаанбадрах	4	470,000	550000	2346650	880000	350000	144000	140000	198000	11110000	16,188,650	228,400
10	Хатанбулаг	6	630,000	750000	3413500	1320000	350000	0	210000	330000	16470000	23,473,500	558,600
11	Хөвсгөл	4	470,000	550000	2190650	880000	350000	372400	140000	198000	11110000	16,261,050	1,010
12	Эрдэнэ	5	550,000	650000	3013000	1100000	350000	465500	175000	264000	13440000	20,007,500	0
13	Сайншанд	9	870,000	1050000	3545000	1980000	350000	837900	315000		29400000	38,347,900	0
14	Замын-Үүд	9	870,000	1050000	2525000	1980000	350000	324000	315000		17520000	24,934,000	513,900
	Дүн	70	7,700,000	9100000	35732335	15400000	4900000	4987700	2450000	2046000	189240000	271556,035	2,234,410

Үүнд: СЕХ-оос өгсөн чиглэлийн дагуу унааны зардал, эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардал, сурталчилгааны зардал, туршилтын болон санал авах өдөр сонгуулийн дүн, мэдээ дамжуулах унааны зардал тус бүрийг онцгойлон анхаарч тухайн нөхцөл байдалд нь уялдуулан аймгийн Сонгуулийн хорооны хуралд танилцуулан хуулий дагуу Сонгуулийн хорооны даргын захирамжийг баталж гаргасны дагуу хуваарилсан билээ.

Шатахууны зардлыг хуваарилахдаа сум болгоноос судалгааг авч албан бичиг, хүсэлтийг үндэслэн нарийвчилсан судалгааны үндсэн дээр хуваарилан шилжүүлж 316555 төгрөгийн хэмнэлт гаргасан. Ингэхдээ УИХ-ын 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахад танай байгууллагаас аудит хийж өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн СЕХ-ноос өгсөн удирдамжийн дагуу нэгэн жигд байдлаар биш тухайн сумын онцлог, үйл ажиллагаа, газар нутгийн онцлог, сонгогчдын оторлож нүүдэллэсэн байдал, сонгуулийн хэсгийн алслагдмал байдал зэргийг шалгуур үзүүлэлт болгон тухайн сумаас ирүүлсэн бодит тооцоо, албан бичгийг үндэслэн хуваарилсан болно.

Туршилтын болон санал авах өдөр дүн мэдээ дамжуулах унааны зардлыг СЕХ-ноос аймгийн төвийн болон сумын төвийн хэсгийг оруулж тооцохгүйгээр энэхүү зардлыг хуваарилахаар зөвлөмж ирүүлсэн. Өөрөөр хэлбэл СЕХ бол орон нутгийн сонгуулийн хэсэг тус бүрийн алслагдмал байдал болон санал тоолох төхөөрөмжөөс дүн мэдээ, өгөгдөл дамжуулах алслагдсан айдаль, зайг тус бүрээр тооцох зааварлах боломжгүй бөгөөд харин Аймгийн Сонгуулийн хорооноос энэхүү зардлыг бодит тооцоонд үндэслэн хэсэг тус бүрийн алслагдмал байдал болон өгөгдөл дамжуулах байршлын зай, замыг үндэслэн тус бүрээр бодитоор тооцож хуваарилсан болно. Үүний дагуу 40-н санал авах байранд нийт

2640,000 төгрөгийг, нэмэлт санал хураалтаар 2 суманд 110,000 төгрөг нийт 2750,000 төгрөгийг хуваарилсан. Ийнхүү бодит тооцоог үндэслэн үр ашигтай хуваарилснаар 704000₮-ийг буцаан төвлөрүүлэн хэмнэлт гаргасан.

№	Сумдын нэр	Хэсгийн тоо	СЕХ-ноос өгсөн санхүүжилт	Туршилтын болон санал авах өдөр дүн мэдээ дамжуулах унааны зардал	Хэтрэлт, хэмнэлт	Тайлбар
1	Айраг	3	165000	198000	-33000	Төвийн хэсгийг хасан хуваарилсан
2	Алтанширээ	3	165000	198000	-33000	
3	Даланжаргалан	4	220000	264000	-44000	
4	Дэлгэрэх	3	165000	198000	-33000	
5	Иххэт	2	110000	187000	-77000	
6	Мандах	4	220000	319000	-99000	Энэхүү 2 суманд нөхөн сонгууль болсон учир дахин хэсэг тус бүр 55.000 төгрөг нийт 110.000 төгрөгийн санхүүжилтийг нэмж хуваарилсан болно.
7	Өргөн	3	165000	198000	-33000	Төвийн хэсгийг хасан хуваарилсан
8	Сайхандулаан	3	165000	198000	-33000	
9	Улаанбадрах	3	165000	198000	-33000	
10	Хатанбулаг	5	275000	330000	-55000	
11	Хөвсгөл	3	165000	198000	-33000	
12	Эрдэнэ	4	220000	264000	-44000	
13	Сайншанд		0	0	0	Энэхүү 2 сумын хэсгүүдийн байрлал нь сумын төв дээр байрлалтай тул хуваарилаагүй болно.
14	Замын-Үүд	8	440000	0	440000	
Дүн		48	2640000	2750000	-110000	

Сурталчилгааны зардлыг СЕХ-ноос саналаа хэрхэн өгөх /COVID-19 хүрээнд/, саналын хуудас хэрхэн тэмдэглэх, санал авах байрны байршил, бусад мэдээ мэдээллийн тухай сурталчилгааг аймаг, нийслэлийн хэмжээнд өөрсдийн боломж бололцоог ашиглан LED болон урсдаг дэлгэц, авто зам болон гудамжны сурталчилгааны самбар, орон нутгийн телевиз, радио, сонинг ашиглан сурталчилгаа хийхэд зарцуулах гэсний дагуу сумдын иргэдийг мэдээ, мэдээллээр хангах мөн иргэдийг сонгуульд идэвхтэй хамруулахын тулд сумын төвийн айл өрх, алслагдсан багийн айл өрхүүдэд сонгуулийн хороонд ажиллаж буй сурталчилгааны багийхан биечлэн очиж ажиллах зайлшгүй шаардлага гарсны улмаас сурталчилгааны зардлаас нийт 1490000₮-ийг шатахууны зардлыг захиран зарцуулсан байна. Учир нь хөдөө сумдад ийнхүү СЕХ-ноос иүүлсэн зааварт байгаа шиг телевиз, радио, дэлгэц, самбараар сурталчлах боломжгүй бөгөөд түүнчлэн богино орон нутагт тухайн сум, багт тохирсон цөөн тоогоор сонин хэвлүүлэх ямар ч боломжгүй бөгөөд үүрэн холбооны сүлжээ, интернэт ашигладаг сонгогчдын тоо ч ховор байгаа юм. Иймд сурталчилгааны зардлыг шатахууны зардал болгон ашиглаж хөдөө айлуудаар, багуудаар биечлэн явж мэдээлэл хүргэх, сонгогчдын боловсролыг ахиулах, сонгуулийн ойлголт өгөх, сурталчилгаа хийхээр ажилласан болно. /Мэдээлэл, сурталчилгааг олон нийтэд түгээхийн хувьд зарим сумдын хүн амын тархмал байдал, мэдээллийн хэрэгслүүдийн хомс байдал зэрэг нь энэхүү зардлаас зарцуулахад хүргэсэн/

Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардал: СЕХ-ноос Санал авах байрыг гэрэлтүүлэх, эрчим хүчний эх үүсвэр дутагдалтай болон цахилгаан тасарсан үед ашиглах мотор түрээслэх зориулалтаар нийт 70 хэсгийн 70 хувьд нь 1 санал авах байрт 50000₮-өөр тооцож хуваарилахаар зөвлөмж ирсэн. Гэвч бодит байдал дээр цахилгааны эх үүсвэрийг эрсдэл бий болсон үед найдвартай байлгах хуулийн ерөнхий зарчмын дагуу бүх хэсэгт уг зардлыг хуваарилах шаардлагатай болсон. Учир нь цахилгааны найдвартай байдал нь бүх хэсэгт байх шаардлагатай бөгөөд төвийн найдвартай эрчим хүсинд холбогдсон ч гэсэн эрсдэл бол байсаар байдаг. Иймд бүх хэсгүүдийн найдвартай байдлыг хангаж, эрсдэл бий болсон үед хэвийн ажиллагааг хангах зорилгоор бүх санал авах байрт уг зардлыг тэгшитгэн хуваарилсан болно. Иймд 1 санал авах байранд 35000₮-өөр тооцон нийт 70 санал авах байранд 2450,000 ₮-ийг хуваарилсан болно.

Сумдын сонгуулийн хороо нь энэхүү зардлыг мотор ажиллуулахдаа тухайн моторын цаг хугацаа, ашиглалтын хугацааны тайлбарыг сайн бичүүлж хянасан.

Болзошгүй зардал: Энэхүү зардлыг цаг агаар хүндэрсэн үед хэсгийн хороонд ашиглана. Мөн байгалийн гэнэтийн аюул, цаг агаарын нөхцөл байдал хүндрэх, зам хаагдах, холбоо тасрах тохиолдолд хэрэглэнэ гэсний дагуу сумын сонгуулийн санал авах байрууд гэнэтийн байдалд бэлэн байлгах, сонгогч, сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхээ шалгах, сонгуулийн хороодын ажлыг хэвийн явуулах үйл ажиллагааны явцад коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор тухайн зардлыг хэрэглэнэ. Мөн энэхүү зардлаар сонгууль болох өдөр Халдваргүйтэлийн ажилтан бүрт олгох хоолны мөнгийг олгосон.

Бодит байдал дээр Мандах, Иххэт, Дэлгэрэх сумдын хувьд эрчим хүчний найдвартай эх үүсвэр бэлтгэхэд мотор түрээслэх болон түүний шатахууныг нөөцөлж бэлэн байдлыг хангах үед тухайн зардал нь дутсан учир энэхүү зардлаас гаргаж зарцуулсан байна. Харин аймгийн СХ-ны нягтлан бодогчоос сумдын санхүүгийн тайланг хүлээж авахдаа тухайн зөрчлийг мэдсэн бөгөөд тайлбар бичиж зарцуулсан байсан. Энэхүү зардлаас 1529300 төгрөг хэмнэгдэж буцаан төвлөрүүлсэн байна.

Аймгийн Сонгуулийн хорооноос шатахууны зардал болох 750,000₮-ийн зардлыг сонгуулийн хороонд ажиллаж байгаа гишүүн тус бүрт олгосон. Энэхүү зардлын зарцуулалтыг 2020 оны 08 сарын 28-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 28-нийг хүртэлх 2 сарын хугацаанд ажиллахад нь зориулж өгөн нэг мөр бичиүүлж авсан болно. Энэхүү хугацаанд сонгуулийн хорооны гишүүн тус бүрт 68000 төгрөгийн талон олгосон бөгөөд тэдний хувьд 2 сарын турш сонгуулийн ажилд хувийн унаагаа ашиглаж ажилласан тул зохих замын хуудсыг нь бичүүлж авсан. Энэ хугацаанд аймгийн сонгуулийн хорооны гишүүд хариуцсан сумдаа ажиллах болон аймгийн төвд сонгуулийн хорооны ажлаар явсан бүх ажил орсон болно.

Мөн сонгуулийн хорооны гишүүдийн хурал болон сургалтын үйл ажиллагааны үед цайны завсарлагааны бүтээгдэхүүн авсныг СЕХ-ноос чиглэл өгсөний дагуу гишүүдэд хурал, сургалтын үйл ажиллагаа зохион байгуулах өдрүүдэд өдрийн хоолны мөнгийг тооцож хуваарилна гэсний дагуу зардлыг захиран зарцуулсан.

Танай аудитын дүнэлтэд тусгагдсан АСХ-ны зардлын төсвөөс 456.8 төгрөгийг хүнс, ахуйн хэрэглээний зүйлсийг худалдан авсан нь хэмнэлтгүй зарцуулсан гэж дурьдсан байна. Гэвч орон нутгийн сонгууль нь маш их ачаалалтай, техник зохион байгуулалтын ажил ихтэй сонгуулийн хорооны гишүүдээс өдөр шөнөгүй ажлын бус цаг, амрултын өдрүүдээр 2 сар гаран

ажилласан. Имид тэдгээр хүмүүсийн ажиллах нөхцөлийг хангах үүднээс цайны болон ариун цэврийн бүтээгдэхүүн худалдан аван ажилласан нь тэдгээр хүүсийг идвхжүүлэх нэг арга болж байсан юм. Түүнчлэн АСХ-ны гишүүд, нягтлан бодогч, бичиг хэргийн ажилтнууд нь өөрийн үндсэн ажлаас чөлөөлөгдөхгүйгээр давхар үүрэг хүлээн, сонгуулийн ажлыг яаралтай зохион байгуулж ирсний хувьд өдрийн цайны цаг, амралтын өдөр, оройн цагийг ашиглан ажиллаж байсан тул цайны бүтээгдэхүүн авах зайлшгүй шаардлага үүсч байсан юм.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 124 дүгээр тогтоолоор батлагдсан журмыг хэрэгжүүлэх хүрээнд Улсын нөөцийн газраас аймгийн Сонгуулийн хороонд сонгуулийн ажилтны бээлий болон иргэдэд тараах хүсний бээлий, мөн гар ариутгах бодис зэргийг л хүлээлгэн өгсөн. Өөр хэрэгсэл Засгийн газрын 124 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын дагуу олгоогүй. Харин аймгийн Сонгуулийн хороо аймгийн Онцгой байдлын газартай харилцан тохирсны үндсэн дээр УИХ-ын сонгуулийн үеэр ашиглаад үлдсэн амны хаалтыг аймгийн Онцгой байдлын газарт хүлээлгэн өгсөн байсан бөгөөд тэр нөөцөөс нийт 3000 амны хаалтыг авч олон сонгогчтой төвлөрсөн сумдад олгож тайланг нь гаргуулан авсан болно. Амны хаалтыг энэ удаагийн сонгуульд улсын нөөцөөс огт өгөөгүйг харин аймагт зохицуулан бага зэргийг олгосон нь огт хүрэлцээгүй зарцуулагдан дууссан болно.

Сумдын сонгуулийн хороодын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулахаар УИХ-ын сонгуулийн санхүүгийн тайланд танай байгууллагаас хийсэн аудитын зөвлөмжийг сайтар баримтлан ажилласан бөгөөд сумдад санхүүжилтийг олгохдоо орон нутгийн онцлогийг харгалзан ялгамжтай хуваарилах болон тухай бүр албан бичгээр зарцуулалтын тайлбар зөвлөмжийг хүргүүлэн байнгын зөвлөгөө өгч ажилласан. Харин зарим сумдын сонгуулийн хороодоос зөвлөмжийг зөрчсөн байдалтай нь холбогдуулан тайлбар, албан бичгийг нь аван ажилласан болно.

ДАРГА



Н.ХОНГОРЗУЛ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР

Аудитын төслөөр хүргүүлсэн тайланд ирүүлсэн тайлбартай танилцаж дараах тайлбар өгч байна.

1. Аудитын дүнгийн 2.1 дэх хэсэгт сурталчилгааны зардал, болзошгүй зардлын талаар өөрчлөлт орууллаа.
2. АСХ-ны гишүүдэд шатахуун зарцуулсан тайлбарыг хүлээн авч аудитын дүнгийн 2.1 дэх хэсгээс хаслаа.
3. Бусад тайлбарт засвар оруулах шаардлагагүй гэж үзлээ.

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД:

ГҮЙЦЭТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

Ц.ЛҮНДЭГМАА

ГЭРЭЭТ АЖИЛТАН

З.ДАВААНЯМ

Б.АРИУНБААТАР

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ч.ХЭРЛЭНЧИМЭГ

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.АРИУНАА

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2020 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/15

Дорноговь аймаг, Сайншанд сум

Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн Аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаал, 2016 оны А/92 тоот тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12 дугаар зүйлийн 40 дэх заалт, 2018 оны А/207 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг аймгийн сонгуулийн хороонд хүргүүлсүгэй.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ч.АРИУНАА

• 440010078